Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ...
дугаар албан бичгийн ...... дүгээр хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 25 — Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Зорилтот түвшин | Санхүүжилт сая.төгрөг | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | | | | |
| | | | | | | | | | | | НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | |
| | | | | | | | | | | | 1.4.2 Нийтийн тээвэр, логистик | |
| 103 | НХТЖҮ Ч-9.22.2 | Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд станц барих бэлтгэл хангах | НТБГ, ЗТ-2 ОНӨҮГ | НТ | 2023 | - | Зураг төсөл боловсруулах ажлын явц | хувь | 100 | 300.0 | Цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төслийг боловсруулан, хамтран ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 01/07/33 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд БНСУ-ын Кёнсанбуг мужийн холбогдох албан тушаалтан хүрэлцэн ирж, цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төслийн талаар танилцуулсан. Тус уулзалтад Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, Бүртгэл, техник технологийн хэлтсийн дарга нар оролцож санал бодлоо солилцсон. | 10 |
| 104 | | Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх | НТБГ | НТ | 2024 | 1,100 | Шинээр үйлчилгээнд нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл | тоо | 297 | 89,100.0 | Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Ютонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу Yutong ZK6117H загварын их багтаамжийн MNS 4598:2011 стандартын 8.1.1 "Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын үйлчилгээнд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна" гэх шаардлагыг хангасан 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Х.18 "Тэнгэр плаза-Багахангай" чиглэлд, 4 дүгээр сарын 30-ны өдрөөс Х.17 "Тэнгэр плаза-Багануур", 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х.19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х.20 "ЧХНОУНБ-5 шар" чиглэлд үйлчилгээнд нэвтрүүлсэн. | 100 |
| | | | НТБГ | - | 2023 | 1,000 | Өдөрт гарах тээврийн хэрэгсэл | тоо | 1,301 | - | 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 133 чиглэлд 1163 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өдөрт үйлчлэх тээврийн хэрэгслийн гарапт 2023 оны суурь түвшин 1000 тээврийн хэрэгслийн гаралттай харьцуулахад 15.1%-иар, 2024 оны суурь түвшинээс 19 тээврийн хэрэгслээр гараптаар буюу 1.7%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 106 | (МУХТ-2025-7.1.2) НХТЖҮ Ч-9.21.3 | Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх | НТБГ | - | 2023 | 15 | Чиглэлийн тоо | тоо | 20 | - | Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Ютонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур болон Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах үүднээс Х.17 Тэнгэр плаза-Багануур, Х.18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд нийт 3 тээврийн хэрэгсэл, Чингис хаан олон улсын нисэх буудал руу Х.19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х.20 "ЧХНОУНБ-5 шар" гэсэн 2 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлээд байна. Мөн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/17 дугаар тушаалаар Х.4" Нисэх-5 шар-Гандан-Халдварт" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан үйлчилгээнд гаргасан. | 100 |
| 107 | | Гэр хорооллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх | НТБГ | - | 2023 | - | Чиглэлийн тоо | тоо | 5 | - | Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээ хүрээгүй суурьшлын цэгүүдэд холбогдох судалгааг хийн, 8 чиглэлд дунд багтаамжийн 17 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Цаашид гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн богино эргэлтийн чиглэл нээх боломж нөхцөлийг тодорхойлохоор Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт шинээр төлөвлөгдөж хийгдсэн 15 авто замын чиглэлийг судлах ажил хийгдэж байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 108 | (МУХТ-2025-7.1.2) НХТЖҮ Ч-9.21.3 | Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох, салбарыг бие даасан болгох | НТБГ | - | 2023 | 139 | Нэмэгдүүлэх зорчигч | тоо, сая/жилд | 173 | - | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах 25/14 дүгээр тогтоолыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж иргэд 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжтой болсон. Нийтийн тээврээр зорчсон төлбөрийг зориулалтын картаас гадна банкны карт, гар утасны аппликейшн, QR код, бэлэн мөнгөөр төлөх боломжийг бүрдүүлэн ажилласнаар 2025 оны эхний 5 сарын байдлаар 68.9 сая зорчигч тээвэрлэж, 22.3 тэрбум төгрөгийн орлого олсон нь өмнөх оны мөн үеэс 6.6 сая зорчигч буюу 9.2 тэрбум төгрөгийн орлогыг илүү төвлөрүүлсэн үзүүлэлттэй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/344 дүгээр захирамжаар Нийтийн тээврийн үйлчилгээний зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ"-нд шилжүүлэх цогц арга хэмжээ авах тооцоо судалгаа хийн санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.<br>Ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл, салбарын холбоодын төлөөлөлтэй уулзаж "Үр дүнд суурилсан үнэлгээ"-ний талаар мэдээлэл өгч, санал солилцсон. "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI) тогтолцоонд шилжүүлэх системийн нэмэлт хөгжүүлэлтийг Улаанбаатар смарт карт ХХК, Ай Си Ти групп ХК-ийн системүүдэд хийгдэж эхлээд байна. | 100 |
| 109 | | Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох | НТБГ | - | 2023 | 15 | Хүлээлтийн хугацааны бууралт | минут | 13 | - | Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 130 чиглэлд 1152 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Үндсэн чиглэлүүдийн үйлчилгээний дундаж хүлээгдлийн хугацаа 8.1 минут байгаа нь 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад 12%-иар буурсан үзүүлэлттэй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/405 дугаар захирамжаар байгуулагдсан "Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн сүлжээ төлөвлөлтийг судалж, санал, дүгнэлт боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Түгжрэлээс шалтгаалсан нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор богино эргэлтийн чиглэлүүдийг төлөвлөх ажлыг эхлүүлсэн. Үүнд: Энхтайваны өргөн чөлөө дагуу М:1а "5 шар- Мөнгөн завьяа", М:16 "Офицеруудын ордон- Сүхбаатарын талбай" чиглэлийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр нээсэн. Үндсэн М:1 "5 шар-Офицеруудын ордон" чиглэлийн энэ оны 01 дүгээр сарын зорчилт 1,357,280 байсан нь 04 дүгээр сард зорчилт нэмэгдсэн чиглэлүүдийн нийлбэрийн хамт 1,485,809 болж 128,529 зорчилтоор буюу 9.4 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Мөн Хан-Уул дүүрэгт зорчдог иргэдийн нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн зорилгоор богино эргэлтийн Ч:7А "Нисэх-5 Богд компани", М:3А "Архивын ерөнхий газар-Таван богд компани" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс шинээр нээж үйлчилгээнд гаргасан. | 100 |
| 110 | | Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх | НТБГ | - | 2024 | 996 | Тавцан төхөөрөмжтэй тээврийн хэрэгсэл | тоо | 297 | - | 2025 оны 06 сарын 20-ны байдлаар нийтийн тээврийн бүртгэлийн санд 1293 тээврийн хэрэгсэл байгаагаас 79% буюу 1020 автобус нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн, дуут зарлан мэдээлэгч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих нөхцөлийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Тоноглогдсон тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл MAZ - 20, Daewoo - 1, Skywell - 82, Golden dragon - 284, Yutong - 632, Hyundai aerocity - 1 байна. | 100 |
| 111 | | Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих | НТБГ, БНДЗДТГ | НТ | 2023 | - | Барилгын ажлын явц | хувь | 100 | 3,500.0 | Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашны барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.<br>Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашны барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгарсан. Тус компани барилгын ажлыг эхлүүлэхээр болсон ч их багтаамжийн автобус гарааш руу орох, гарах үед зай талбай хүрэлцэхгүй байсан тул байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлэхээр Багануур дүүргийн Засаг Даргын Тамгын Газраас Хот байгуулалт, хотын стандартын газарт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04/441 дүгээр албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. | 30 |
| | | | | | | | | | | | **Хэрэгжилтийн дундаж хувь: /100*7+30*1+10*1/** | **83.2** |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ... дугаар сарын ....-ны өдрийн.....
дугаар албан бичгийн ...... дугээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮНГИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 25 Улаанбаатар хот

| № | Үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | он | түвшин | | | |
| САЛБАРЫН ҮР ДҮН | | | | | | | | |
| 10 | Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 24 хувиар нэмэгдүүлнэ. | Нийтийн тээврээр үйлчлүүлсэн зорчигчид | жилд, сая | 2023 | 139 | 173 | 2025 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар өссөн дүнгээр 78.2 сая зорчигчдод үйлчилгээ үзүүлээд байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25.4%-иар өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 28 | Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 30 хувиар нэмэгдүүлнэ. | Өдөрт үйлчилгээнд гарах тээврийн хэрэгсэл | тоо | 2023 | 1000 | 1301 | Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний 133 чиглэлд ажлын өдөр 1163, амралтын өдөр 945 тээврийн хэрэгсэл, 1280 автобусны зогсоолыг дайран өнгөрч өдөрт 500-520 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлж байна. 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад 15.1%-иар өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| Хэрэгжилтийн дундаж хувь: /100*2/ | | | | | | | | 100 |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ...дугаар сарын....-ны өдрийн .......
дугаар албан бичгийн.... дүгээр хавсралт

# “НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2025 оны эхний хагас жилийн байдлаар)

2025 оны 06 дугаар сарын 26 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай” үндэслэн “Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө”-ний хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагаанд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2025 оны хагас жилийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хүрээнд тус газраас 9 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ба хэрэгжилтийн дундаж 83.2 хувь байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 83.2 хувь байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”-ын 6.5.-т заасан үнэлгээний арга зүйгээр Хэрэгжих хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлгээний 2.хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь бол “Үр дүн хүлээгдэж байгаа” үнэлгээтэй байна.

1.1.Бодлогын баримт бичгийн (МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3-111 “Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих” гэсэн арга хэмжээ хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй” хувийн биелэлттэй байгаа ба дараах ажил хийгдсэн байна. Үүнд:

1. Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашны барилгын зураг төслийг 2022 онд “Эрхэс констракшн” ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.

Багануур дүүргийн “Тээвэр зохицуулалтын алба” ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашны барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр “Наран босголт” ХХК шалгарсан. Тус компани барилгын ажлыг эхлүүлэхээр болсон ч их багтаамжийн автобус гарааш руу орох, гарах үед зай талбай хүрэлцэхгүй байсан тул байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлэхээр Багануур дүүргийн Засаг Даргын Тамгын Газраас Хот байгуулалт, хотын стандартын газарт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04/441 дүгээр албан бичгээр хүсэлт хүргүүлсэн байна.

2.1.Бодлогын баримт бичгийн НХТЖҮЧ-9.22.2-103 “Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд станц барих бэлтгэл хангах” гэсэн арга хэмжээ 30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй” хувийн биелэлттэй байгаа ба дараах ажил хийгдсэн байна. Үүнд:

1. Цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төслийг боловсруулан, хамтран ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 01/07/33 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд БНСУ-ын Кёнсанбуг мужийн холбогдох албан тушаалтан хүрэлцэн ирж, цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд

бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төслийн талаар танилцуулсан. Тус уулзалтад Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, Бүртгэл, техник технологийн хэлтсийн дарга нар оролцож санал бодлоо солилцсон байна.

## ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1. Төлөвлөгөөнд 30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй" хувийн биелэлттэй байгаа 2 арга хэмжээний хэрэгжилтийг хариуцаж байгаа Бүртгэл техник, технологийн хэлтсийн дарга, албан хаагчид тус арга хэмжээний шаардагдах төсөв, зорилтот түвшингээ зөв тодорхойлох, хамтран хэрэгжүүлэх холбогдох байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулах, хэрэгжилтийг сүүлийн хагас жилд эрчимжүүлэх;

2.2.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой, нотлох баримтын хамт тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээг эрчимжүүлж, Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА /Д.ОТГОНЖАРГАЛ/

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА /З.ЦЭВЭЭНДОРЖ/

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц. Б[illegible] /Ц.БЯМБАСҮРЭН/

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ... дугаар сарын ....-ны өдрийн......
дугаар албан бичгийн ...... дугаар хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН НОТЛОХ БАРИМТУУД

2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хот

**Нэг: Зорилт: НХТЖҮЧ-9.22.2**

**Арга хэмжээ:** Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд станц барих бэлтгэл хангах

**Хэрэгжилт**: Цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төслийг боловсруулан, хамтран ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 01/07/33 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд БНСУ-ын Кёнсанбүг мужийн холбогдох албан тушаалтан хүрэлцэн ирж, цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төслийн талаар танилцуулсан. Тус уулзалтад Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, Бүртгэл, техник технологийн хэлтсийн дарга нар оролцож санал бодлоо солилцсон.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

Наадамчдын зам 1200, Арцатын ам
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас: www.transport.ub.gov.mn

2025.01.06 № 01/07/33

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Хамтран ажиллах тухай

Тус газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан "Цахилгаан автобусны цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулж, цахилгаан автобусны хэрэглээг нэмэгдүүлнэ" гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ-тай хамтран хариуцаж ажиллах бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зураг, төсөл хийлгэхээр тусгаад байна.

Иймд цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төсөл боловсруулахад хамтран ажиллахыг хүсье.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваасүрэн ОТГОНЖАРГАЛ
2025.01.06 09:52

*Зураг 1. Зам тээврийн яаманд цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой дэд станц байгуулах зураг төслийг боловсруулахад хамтран ажиллах тухай санал хүргүүлсэн албан бичиг*

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг
Улаанбаатар хот 17100
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас: www.transport.ub.gov.mn

2025.05.21 № 01/08/1161
танай 2025.05.08 -ны № 129 -т

БОДЛОГЫН СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ НТҮГ-ЫН
ЗАХИРАЛ РДАГВА ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай 2025 оны 05 дугаар сарын 08-ны 129 дугаартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах тухай албан бичигтэй танилцлаа.

Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан цахилгаан автобусны цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулж, цахилгаан автобусны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд холбогдох зураг төсөл, төсвийн задаргааг төсөл хэрэгжүүлэх байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг 2026 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тусгуулж, хамтран ажиллах саналтай байна.

Хүндэтгэсэн,

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Давааням ОТГОНЖАРГАЛ
2025.05.21 09:09

*Зураг 2. БСШТ-тэй хамтарч цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой дэд станц байгуулах зураг төслийг боловсруулахад хамтран ажиллах тухай санал хүргүүлсэн албан бичиг*



*Зураг 3. БНСУ-ын цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төсөлтэй танилцах уулзалтын үеэр*

**Хоёр: Зорилт: НХТЖҮЧ-9.22.2**

**Арга хэмжээ:** Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх

**Хэрэгжилт**: Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Юүтонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу Yutong ZK6117H загварын их багтаамжийн MNS 4598:2011 стандартын 8.1.1 "Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын үйлчилгээнд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна" дэх шаардлагыг хангасан 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Х:18 "Тэнгэр плаза-Багахангай" чиглэлд, 4 дүгээр сарын 30-ны өдрөөс Х:17 "Тэнгэр плаза-Багануур", 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар" чиглэлд үйлчилгээнд нэвтрүүлсэн.

2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 133 чиглэлд 1163 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өдөрт үйлчлэх тээврийн хэрэгслийн гаралт 2023 оны суурь түвшин 1000 тээврийн хэрэгслийн гаралттай харьцуулахад 15.1%-иар, 2024 оны суурь түвшинөөс 19 тээврийн хэрэгслээр гаралтаар буюу 1.7%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 10 өдөр  Дугаар [illegible]  Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулж, гадаад
томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа "Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар)" төсөл, арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ", НЗДТГ/202310014-01 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээний хугацаа сунгах гэрээ", НЗДТГ/202310014-02 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ"-ний дагуу нийлүүлэгдсэн нийтийн тээврийн зориулалттай их багтаамжийн ангиллын автобус дээр нэмэлт нийлүүлэлт хийхээр харилцан тохиролцсон НЗДТГ/202310014-03 дугаартай гэрээний дагуу нэмэлтээр нийлүүлэх хот орчмын нийтийн тээврийн зориулалттай их багтаамжийн 10 автобусыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар баталж, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн хотод албан томилолтоор ажиллуулсугай.

2.Томилолтоор ажиллах болон 10 автобусыг Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас Улаанбаатар хот хүргэх тээвэрлэлтийн үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар баталж, Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас, гаалийн татвар, хураамжийн зардлыг 3 дугаар хавсралтаар баталж, Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн зардлаас тус тус санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т зөвшөөрсүгэй.

3.Гадаад томилолтоор ажилласан тухай тайланг ирсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт ирүүлэхийг Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар (Д.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ  Х.НЯМБААТАР

1725022252

*Зураг 4. НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобус хүлээн авах ажлын хэсгийг томилсон тухай захирамж*

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 10 өдрийн
[illegible] захирамжийн
1 дүгээр хавсралт

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЭРЭЭН ХОТОД
АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

| Д/д | Албан хаагчийн нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Д.Отгонжаргал | Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын дарга |
| 2 | Э.Өлзий | Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын Бүртгэл,техник технологийн хэлтсийн Техникийн хяналтын үзлэгийн төв хариуцсан ахлах менежер |
| 3 | Г.Ганбаатар | Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын Бүртгэл, техник технологийн хэлтсийн Техникийн хяналтын үзлэгийн инженер |
| 4 | М.Мөнхзул | Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын Хяналт шалгалтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагч |
| 5 | Г.Тэмүүжин | Нийслэлийн өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн дарга |

*Зураг 5. 10 автобус хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн*



*Зураг 6. Yutong ZK6117H загварын их багтаамжийн автобус*

**Гурав. Зорилт: (МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3**

**Арга хэмжээ:** Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх

**Хэрэгжилт**: Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Юүтонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур болон Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах үүднээс Х:17 Тэнгэр плаза-Багануур, Х:18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд нийт 3 тээврийн хэрэгсэл, Чингис хаан олон улсын нисэх буудал руу Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар" гэсэн 2 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлээд байна. Мөн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/17 дугаар тушаалаар Х:4" Нисэх-5 шар-Гандан-Халдварт" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан үйлчилгээнд гаргасан.







Зураг 7. Х:17 Тэнгэр плаза-Багануур

Зураг 8. Х:18 Тэнгэр плаза-Багахангай



Зураг 9. Чингис хаан олон улсын нисэх буудал руу Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар" гэсэн 2 чиглэлийн автобус

**Дөрөв. Зорилт: (МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3**

**Арга хэмжээ:** Гэр хорооллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх

**Хэрэгжилт**: Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээ хүрээгүй суурьшлын цэгүүдэд холбогдох судалгааг хийн, 8 чиглэлд дунд багтаамжийн 17 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Цаашид гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн богино эргэлтийн чиглэл нээх боломж нөхцөлийг тодорхойлохоор Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт шинээр төлөвлөгдөж хийгдсэн 15 авто замын чиглэлийг судлах ажил хийгдэж байна.




*Зураг 10. Судалгаа хийгдсэн байршил*

**Тав. Зорилт: (МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3**

**Арга хэмжээ:** Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох

**Хэрэгжилт**: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах 25/14 дүгээр тогтоолыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж иргэд 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжтой болсон. Нийтийн тээврээр зорчсон төлбөрийг зориулалтын картаас гадна банкны карт, гар утасны аппликейшн, QR код, бэлэн мөнгөөр төлөх боломжийг бүрдүүлэн ажилласнаар 2025 оны эхний 5 сарын байдлаар 68.9 сая зорчигч тээвэрлэж, 22.3 тэрбум төгрөгийн орлого олсон нь өмнөх оны мөн үеэс 6.6 сая зорчигч буюу 9.2 тэрбум төгрөгийн орлогыг илүү төвлөрүүлсэн үзүүлэлттэй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/344 дүгээр захирамжаар Нийтийн тээврийн үйлчилгээний зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ"-нд шилжүүлэх цогц арга хэмжээ авах тооцоо судалгаа хийн санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл, салбарын холбоодын төлөөлөлтэй уулзаж "Үр дүнд суурилсан үнэлгээ"-ний талаар мэдээлэл өгч, санал солилцсон. "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI) тогтолцоонд шилжүүлэх системийн нэмэлт хөгжүүлэлтийг Улаанбаатар смарт карт ХХК, Ай Си Ти групп ХК-ийн системүүдэд хийгдэж эхлээд байна.



[illegible]

2025 — 01 — 27 — 25/14

Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх
таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний
төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1."Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г тогтоож, хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Б.Батбаясгалан)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс нийслэлийн хэмжээнд мөрдүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-д даалгасугай.

5.Тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА А.БАЯР

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн 25/14
дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ МӨРДӨХ ТАКСИНААС
БУСАД НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

| Д/д | Нийтийн тээврийн хэрэгслийн төрөл | Зорчих чиглэлийн нэр | Төлбөрийн хэмжээ /1 зорчигч төгрөгөөр/ | | Зорчих давтамж |
|---|---|---|---|---|---|
| | | | Насанд хүрсэн хүн | Сургуулийн насны хүүхэд | |
| 1 | Автобус | Хот доторх болон хот орчмын зарим чиглэл | 1000 | 200 | Зориулалтын картаар өдөрт 4 удаа, бусад тохиолдолд зорчих бүрд |
| 2 | Троллейбус | | 1000 | 200 | |
| 3 | Автобус | Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбайн төв зогсоол | 15000 | 7500 | |
| 4 | Автобус | Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-5 шар" | 10000 | 5000 | |
| 5 | Автобус | Улаанбаатар - Багануур | 10000 | 5000 | Зорчих бүрд (Машин цагийн хэрдлээр сэжүүлэх бол зориулалтын картаар өдөрт 4 удаа) |
| 6 | Дунд болон бага оврын тээврийн хэрэгсэл | | 15000 | 7000 | |
| 7 | Автобус | "Багахангай-Дунжингарав худалдааны төв" | 6000 | 4000 | |

Жич: "Зориулалтын карт"-д нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо ашиглах албан ёсны төлбөрийн биет болон биет бус карт, төлбөрийн аппликейшн /QR/, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан сурагчийн картууд хамаарна.

*Зураг 11. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн тогтоол 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/14 дугаар*

**Зургаа. Зорилт: (МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3**

**Арга хэмжээ:** Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох

**Хэрэгжилт**: Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 130 чиглэлд 1152 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Үндсэн чиглэлүүдийн үйлчилгээний дундаж хүлээгдлийн хугацаа 8.1 минут байгаа нь 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад 12%-иар буурсан үзүүлэлттэй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/405 дугаар захирамжаар байгуулагдсан "Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн сүлжээ төлөвлөлтийг судалж, санал, дүгнэлт боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Түгжрэлээс шалтгаалсан нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор богино эргэлтийн чиглэлүүдийг төлөвлөх ажлыг эхлүүлсэн. Үүнд: Энхтайваны өргөн чөлөө дагуу М:1а "5 шар- Мөнгөн завьяа", М:1б "Офицеруудын ордон- Сүхбаатарын талбай" чиглэлийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр нээсэн. Үндсэн М:1 "5 шар-Офицеруудын ордон" чиглэлийн энэ оны 01 дүгээр сарын зорчилт 1,357,280 байсан нь 04 дүгээр сард зорчилт нэмэгдсэн чиглэлүүдийн нийлбэрийн хамт 1,485,809 болж 128,529 зорчилтоор буюу 9.4 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Мөн Хан-Уул дүүрэгт зорчдог иргэдийн нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн зорилгоор богино эргэлтийн Ч:7А "Нисэх-5 Богд компани", М:3А "Архивын ерөнхий газар-



Таван богд компани" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс шинээр нээж үйлчилгээнд гаргасан.







*Зураг 12. Үйлчилгээнд ажиллаж буй чиглэлийн зураглал*

**2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс**

- **М:1А чиглэлд 5 тээврийн хэрэгсэл**
- **М:1Б чиглэлд 4 тээврийн хэрэгсэл**







**Долоо. Зорилт: (МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3**

**Арга хэмжээ:** Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх

**Хэрэгжилт**: 2025 оны I улирлын байдлаар нийтийн тээврийн бүртгэлийн санд 1293 тээврийн хэрэгсэл байгаагаас 79% буюу 1020 автобус нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн, дуут зарлан мэдээлэгч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих нөхцөлийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Тоноглогдсон тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл MAZ - 20, Daewoo - 1, Skywell - 82, Golden dragon - 284, Yutong - 632, Hyundai aerocity - 1 байна.



*Зураг 13. Yutong маркийн автобусны тоноглол*



*Зураг 14. Golden dragon маркийн угсраа автобус*

**Найм. Зорилт: (МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3**

**Арга хэмжээ:** Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих

**Хэрэгжилт**: Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашны барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.

Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашны барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгарсан. Тус компани барилгын ажлыг эхлүүлэхээр болсон ч их багтаамжийн автобус гараашруу орох, гарах үед зай талбай хүрэлцэхгүй байсан тул байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлэхээр Багануур дүүргийн Засаг Даргын Тамгын Газраас  Хот байгуулалт, хотын стандартын газарт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04/441 дүгээр албан бичгээр хүсэлт хүргүүлсэн.

БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ГАЗАРТ

Мэдээлэл хүргүүлэх тухай

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд тус дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих төслийн барилгын ажлын тендер сонгон шалгаруулалт нийслэлийн Худалдан авах ажиллагааны албанд зарлагдаж "Наран босгоот" ХХК шалгарч НХААГ/20250101027 дугаартай гэрээ байгуулагдсан байна.

Гэрээ болон хийгдсэн зураг төсвийн дагуу барилгын ажлыг эхлүүлэх гэсэн боловч том оврын автобус гарааш руу орох, гарахад зай талбай хүрэлцэхгүй төвөгшилтэй байгаа тул байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлсний дараагаар ажлыг эхлүүлэхээр төлөвлөгдөж байна.

Хавсралт 1 хуудастай.

Багануур дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын тамгын газрын дарга
Пүрэвдоо Баттушиг
2025 05 01 14:33

*Зураг 17. Багануур дүүргийн ЗДТГ-аас Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын гараашны барилгын ажлын явцын талаар ирүүлсэн мэдээлэл*

БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН
СТАНДАРТЫН ГАЗАРТ

Координатыг шилжүүлэх тухай

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Нийтийн тээврийн гарааш"-ын барилгыг "Наранбосгол" ХХК гүйцэтгэхээр Нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна.

Уг ажлын зураг төсөлд танай газраас 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн МЗХ2021/24-003 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг гаргаж, эргэлтийн цэгийн солбицолд тусгагдсан координатаар ажлын зураг төсөл магадлалаар орж батлагдсан байна.

Энэхүү зураг төслөөр угсралтын ажлыг эхлүүлэх явцад том оврын автобус гараашруу орох, гарахад зай талбай хүрэлцээгүй төвөгшилтэй байгаа тул байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлэн өгнө үү.

Хавсралт 3 хуудастай.

Багануур дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын тамгын газрын дарга
Пүрэвдоо Баттушиг
2025.04.29 17:02

*Зураг 15. Байршлын схемийн хуудаст заасан координатыг 3-4 метр зөөж шилжүүлэхээр Хот байгуулалт, хотын стандартын газарт хүргүүлсэн албан бичиг*



*Зураг 16. Гараашны барилгын ажлын явцын зураг*

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ... дугаар сарын ....-ны өдрийн.....
дугаар албан бичгийн ...... дугаар хавсралт

# НИЙСЛЭЛ ХОТЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 2021-2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугээр сарын 25 Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | | |
| Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтэцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ. | | | | | | | |
| 1 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | 9.21.1 Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. | - | - | Нийслэлийн төсөвт нийтийн тээврийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах төсөв тусгагдаагүй тул Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжийн Төлөөлөн удирдах хорооны хурлаар хэлэлцүүлэн, Нийтийн тээврийн салбарын Мастер төлөвлөгөөг гүйцэтгүүлэх чиглэлээр шийдвэр гаргуулан хамтран ажиллаж байна. ТЭЗҮ-г боловсруулах ажлын хүрээнд Их Британид төвтэй Royal Haskoning DHV компаниас олон улсын нийтийн тээврийн шинжээчийн баг ирсэн бөгөөд 3 удаагийн уулзалт зохион байгуулан мэдээлэл солилцон ажиллаж байна. Мөн Дэлхийн банкны суурин төлөөлөгч нарт Нийслэлийн нийтийн тээврийн газраас мастер төлөвлөгөөнд тусгуулах 77 төрлийн саналыг боловсруулан хүргүүлэн ажилласан байна.<br>"Улаанбаатар хотын нийтийн тээврийн стратеги боловсруулах" ажлын хүрээнд Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид холбогдох саналыг хүргүүлж хамтран ажилласан бөгөөд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар AIRI-FEM түншлэл/Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн болон Far East BRT Planning Co.,Ltd нараас бүрдэх/ хамтарсан гэрээг 2024 оны 04 дүгээр сард байгуулагдсан. Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид нийт 5 удаагийн саналыг хүргүүлсэн.<br>Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, хүлээгдлийн хугацааг багасгах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар чиглэлийн дахин төлөвлөлтийг | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 74 чиглэлийн замналыг шинээр нээсэн. Мөн хот орчмын 21 чиглэл, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан үндсэн 7 чиглэл, дунд оврын 10 чиглэлийг шинээр нээж, 42 чиглэлийн замнал хааж, 25 чиглэлийн замналд зогсоол нэмж, 6 чиглэлийн замналаас зогсоол хасаж, 23 чиглэлийн замналд зогсоолын нэршил өөрчилж, 31 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.<br>2025 оны хагас жилийн байдлаар Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд зөвлөх багаас ирүүлсэн "Нийтийн тээврийн стратеги"-ийн тайлантай танилцаж тайланд тусгах 9 саналыг нэгтгэн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/02/102 дугаар албан бичгээр, "Нийтийн тээврийн дүн шинжилгээ"-ний тайланг ирүүлсэнтэй танилцаж, нэмэлтээр тусгах 6 саналыг нэгтгэн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/02/355 дугаар албан бичгээр төслийн нэгжид тус тус хүргүүлсэн. | | - |
| 2 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | 9.21.2. Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна. | - | - | **2021 он:** Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн шинээр баригдах "Аэро сити" буюу дагуул хотын нийтийн тээврийн үйлчилгээний 4 чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан, батлуулсан.<br>Дээрх ажлын хүрээнд Хөшигийн хөндийн "Чингис хаан" олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орж, үйл ажиллагаа нь 2021 оны 07 сарын 04-ний өдрөөс эхэлсэн хэдий ч Ковид-19 цар тахалтай холбогдуулан үйл ажиллагаа түр зогсоосон байна.<br>**2022 он:** Улаанбаатар хотын хаяа дагуул 16 хот тосгодын 13 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 16 чиглэлд хүргэж, өдөр тутам 60 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлсэн.<br>**2023 он**: Улаанбаатар хотын хаяа дагуул 16 хот тосгодын 14 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 16 чиглэлд хүргэж, өдөр тутам 60 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Дагуул хот байгуулах байршил буюу Чингис хаан олон улсын нисэх буудалд 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 10-ны хүртэлх хугацаанд 586 зорчигч тээвэрлэсэн.<br>**2024 он:** Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 18 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 19 чиглэлд хүргэж, өдөр тутам 73 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | **2025 оны хагас жилийн байдлаар** Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 20 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 21 чиглэлд хүргэж, өдөр тутам 85 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. | | |
| 3 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | 9.21.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна. | | | 1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Яармагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км трасст тулгуур багана байрлуулах ажил хийгдэж эхэлсэн. Туул голын ай сав газар байрлалтай 3-9 дүгээр тулгуур баганын нийт 28ш шон суурийн өрөмдлөг, арматурчлал, бетоны ажил хийгдсэн. Дүүжин замын тээврийн төслийн хоёрдугаар шугам буюу Үндэсний соёл амралтын хүрээлэнгээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэн чиглэлийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил эхэлж, дэд бүтэц, суурь судалгааны ажлууд хийгдэж эхэлсэн. Дүүжин замын тээвэрт Европын Холбооны стандартыг нутагшуулах зорилгоор "Хүн тээвэрлэх зориулалттай дүүжин замын тээврийн байгууламжийн аюулгүй байдлын шаардлага"-тай холбоотой 15 стандартыг СХЗГ-ын Авто тээврийн стандартчиллын техникийн хороогоор батлуулан, MNS бүртгэлд шилжүүлсэн.<br>2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх "Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар" 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг хэлэлцүүлэгт Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон.<br>2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.<br>Азийн хөгжлийн банк нь "Тусгай замын автобус BRT төсөл"-ийн санхүүжилтийн зээлийн судалгааны ажлын хэсэг байгуулан 2025 оны 04 дүгээр сарын 28-аас 05 дугаар сарын 09-ний хооронд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, мэдээ мэдээлэл солилцож санал хүргүүлэн ажилласан. | 70 | Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Шинэ бүтээн байгуулалт ХК хариуцан ажиллаж байна. |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | 3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарч, төслийн бүтээн байгуулалтын ажлын (EPC) гүйцэтгэгчийг шалгаруулах хоёрдугаар шатны тендерийн баримт бичигт санал, зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, хурлаар тендерийн баримт бичгийг хэлэлцэж холбогдох санал, мэдээллийг өгч ажилласан.<br>4."Буянт-ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл "-ийн техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг төслийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ боловсруулахаар шалгарсан. Тус ажлын дагуу Трамвайн замын төлөвлөлтийн трассын зураг төсөлд тусгах саналыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/02/1003 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 4 | 9.22. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоолтой болно. | 9.22.1 Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна. | | | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд:<br>**2021 онд 35 автобус:**<br>"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ нь Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 оны 06 дугаар сард 35 их багтаамжийн автобус<br>**2022 онд 71 автобус:**<br>-10 ширхэг давхар автобус<br>-1 ширхэг их багтаамжийн цахилгаан автобус<br>-Xiamen golden dragon bus XML6105J15C загварын их багтаамжийн 60 ширхэг автобус<br>**2023 онд 364 автобус:**<br>-"Xiamen Golden Dragon Bus" ХХК-ийн их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 ширхэг автобус<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Тэнүүн огоо" ХХК-ийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн НН ТГ23001 тоот | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | гэрээ дагуу 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй SKYWELL маркын автобус<br>-50 ширхэг дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй HYUNDAI COUNTY маркын автобус<br>-Yutong Bus Co.,Ltd-ийн үйлдвэрлэсэн их багтаамжийн дизель евро-5 хөдөлгүүртэй 35 ширхэг автобус<br>**2024 онд 596 автобус:**<br>- 2024 онд 565 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй Yutong маркийн их багтаамжийн автобус, 31 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй угсраа автобусаар буюу нийт 596 автобусаар парк шинэчлэлт хийсэн.<br>**2025 оны хагас жилийн байдлаар 10 автобус:**<br>Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, "Yutong bus" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын евро-5 дизель хөдөлгүүртэй, их багтаамжийн 10 автобусаар парк шинэчлэлт хийж, Багахангай дүүргийн чиглэлд 1, Багануур дүүргийн чиглэлд 2, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлд 7 автобусыг тус тус үйлчилгээнд гаргасан.<br>Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор "Нийслэлийн Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажил"-ын хүрээнд 2021-2025 онд евро-5 /дизель/ маркийн 975 автобус, цахилгаан хөдөлгүүртэй 101 автобусаар нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1076 автобусаар нэмэгдүүлж ажилласан. | | |
| 5 | | 9.22.2 Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг | - | - | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1306 дугаартай "Эрх шилжүүлэх тухай" захирамжаар (Улаанбаатар) орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 250,000 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж худалдан авах нээлттэй тендерийг (www.tender.gov.mn) Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 1 сарын хугацаатай зарлан Азсеть ХХК шалгарч Азсеть ХХК 223,791 | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | байгуулсан байна. | | | сая төгрөгөөр 1,250,000 төгрөгийн баталгаа гарган тендерт шалгарсан.<br>БММЗ эцэс цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж байршуулах хүчин чадалтай ажлын гүйцэтгэл дууссан. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, хүлээн авах комисс томилох тушаалд санал авч ажилласан.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/83 дугаартай тушаалын дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх "Цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжийн ажлын үе шат бүрд захиалагчийн хяналт тавьж, байнгын ашиглалтад оруулах үүрэг бүхий" ажлын хэсэг байгуулагдсан.<br>Уг ажлын хэсэг БММЗ эцэст байрлах троллейбусны 2*692 кВа чадалтай 6/0,6 кВ-ийн татах дэд станцыг 2*800 кВа чадалтай 6/0,4 кВ-ийн өргөтгөсөн дэд станцыг 2024 оны 08 дугаар сард хүлээн авсан.<br>Цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төслийг боловсруулан, хамтран ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 01/07/33 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд БНСУ-ын Кёнсанбүг мужийн холбогдох албан тушаалтан хүрэлцэн ирж, цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төслийн талаар танилцуулж, санал бодлоо солилцсон.<br>2025 оны 05 дугаар сарын 21-ний 01/08/1161 дугаартай албан бичгээр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах ажлын хүрээнд холбогдох зураг төсөл, төсвийн задаргааг төсөл хэрэгжүүлэх байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг 2026 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тусгуулах талаар хамтран ажиллах санал хүргүүлж ажилласан. | | |
| 6 | | 9.22.3 Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг | - | - | 1.УИХ-ын гишүүн Ц.Мөнх-оргилын санаачилгаар Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хороонд байрлах 2 эцсийн зогсоолыг тохижуулах ажлыг "Үүлэн сүндэр" ХХК нь гүйцэтгэж, иж бүрэн тохижуулах Бэлхийн эцэс, Тоосгоны эцсийн хүлээлгийн дулаан 2 | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэтгэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | сайжруулж, стандартын дагуу байгуулна. | | | зогсоолын ажил болон чиглэлийн тээврийн хэрэгслийн 15 дундын зогсоолын ажил бүрэн хийгдэж, гүйцэтгэл 100 хувьтай байна.<br>2.УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачилгаар Зам, тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянгын авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн 19 зогсоолыг тохижуулахаар "Цагаан толгойн нуур" ХХК шалгарч 6 зогсоолын ажлыг хийж дууссан ба ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.<br>3.Ерөнхий менежерийн 2023 оны А/45 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж нийтийн бие засах газар болон барилга байгууламжтай 6 эцсийн зогсоол, нийтийн тээврийн үйлчилгээний тохижилт хийгдсэн зогсоолуудын арчлалт ашиглалтыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэн аж ахуй нэгжид хариуцуулахаар тендер зарлан сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж Дижитал концефт ХХК (GS-25)-нд Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолыг засварлаж тохижуулах, ашиглалтыг хариуцуулахаар шийдвэрлэн 5 зогсоолыг хүлээлгэн өгсөн.<br>4.2024 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2,5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан.<br>5.Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхорын эцсийн автобусны зогсоолын тохижилтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.<br>Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны шинэ эцэс, хуучин эцэст дулаан автобусны зогсоолыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>Тайлант хугацаанд нийт 3 байршилд шинээр 3 дулаан зогсоолыг байнгын ашиглалтад оруулсан. | | |
| 7 | 9.23. Улаанбаатар хотод ачаа тээврийн логистик, зорчигчдын ая | 9.23.1 Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, | - | - | **Зүүн логистик:** Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/311 дугаар захирамжаар "Нийслэлийн зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв" байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр "Туушин" ХХК, нийслэлийн хүлээсэн эрх, үүргийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний | 50 | 1. "Улаанбаатар хотын зүүн хэсэгт олон улсын ачаа, тээвэр, |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | тухтай зорчих нөхцөлийг хангасан зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулна. | зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна. | | | өдрийн 01/02 дугаартай хамтран ажиллах гэрээгээр "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК хариуцан ажиллаж байна.<br>1.Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/131 захирамжаар батлагдсан Улаанбаатар хотын зүүн хэсэгт ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах ажлын хэсгийн хурал 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр болсон. Уг хуралдаанд Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо, тээвэр зуучийн терминал эзэмшин үйлчилгээ явуулдаг 11 байгууллага, төрийн холбогдох байгууллагуудыг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулагдаж мэдээлэл авч ажилласан.<br>2.Зам Тээврийн Сайдаас 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид ирүүлсэн 01/445 дугаартай албан бичгийн дагуу Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төв байгуулах байршлыг тогтоох судалгааны Ажлын хэсэгт Нийслэлээс орж ажиллах албан тушаалтнуудын мэдээллийг Зам тээврийн яаманд хүргүүлсэн. Энэхүү ажлын хэсгийн дүгнэлтээр "Улаанбаатар хотын зүүн хэсэгт олон улсын ачаа, тээвэр, логистикийн төв байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх байршил болон теслийн холбогдох үзүүлэлтүүд тодорхой болохоор хүлээгдэж байна.<br>**Баруун логистик:** Олон улсын худалдаа, логистикийн төв ХК нь баруун хэсэгт төрөлжсөн логистикийн "Хангарди терминал", "Төмөр замын хяналтын бүс", "Хүнс, бараа бүтээгдэхүүний бөөний худалдааны төв" төслүүдийн гүйцэтгэгчээр ажиллаж байна.<br>Нийслэл хотод ачаа тээвэр логистикийн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулахаар Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/485 дугаар захирамжаар "Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах шуурхай удирдлагын багийг байгуулах тухай" ажлын хэсгүүд байгуулагдсан.<br>"Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан баруун логистик төв байгуулах зорилт арга хэмжээнд тусгах саналыг 2025 оны 03 дугаар сарын 17-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт /erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын цахим систем/-ээр хүргүүлсэн. | | логистикийн төв байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх байршил, болон теслийн холбогдох үзүүлэлтүүд тодорхой болохоор хүлээгдэж байна.<br>2. "Улаанбаатар хотын баруун хэсэгт олон улсын ачаа, тээвэр, логистикийн төв байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ төсвийн тодотголоор хасагдсан. |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Батлагдсан төсөв /сая, төг/ | Гүйцэт-гэл сая, төг | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | Хэрэгжилтийн дундаж хувь /100%*5+70%*1+50%*1/ | | | | | 88.57 | |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ... дугаар сарын ....-ны өдрийн......
дугаар албан бичгийн ...... дугаар хавсралт

# НИЙСЛЭЛ ХОТЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 2021-2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 05 дугээр сарын 30 Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | | | | | | | | |
| Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ. | | | | | | | | | | | | | |
| 1 | 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ. | 9.21.1 Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. | Нийтийн тээврийн чиглэлийн давхцал буурах хувь | Хувь | 2020 | 0 | 2025 | 30 | - | - | Нийтийн тээврийн чиглэлийн дахин төлөвлөлтөөр үндсэн 6 гол гудамж замаар 375, тойрог 8 чиглэлд 74, бусад гудамж замаар дайран өнгөрөх 40 чиглэлд 494, хот орчмын 15 чиглэлд 87 автобусаар үйлчилгээнд ажиллахаар төлөвлөсөн боловч иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу 4 чиглэлийн маршрутад өөрчлөлт оруулан, 71 чиглэл маршрутыг эргэн сэргээсэн. Чиглэлийн давхцалын судалгааг нийтийн тээврийн үйлчилгээний 111 чиглэлийн дайран өнгөрөх 1170 зогсоолоос 70 хувиас дээш давхцалтай 12 чиглэлийг харьцуулан шинжилж, 2 чиглэлийн давхцалыг арилгасан Нийтийн тээврийн чиглэлийн давхцал 11 хувь буурсан байна. | 70 | Иргэдээс шинэ төлөвлөлттэй холбоотой санал, хүсэлт, гомдол ихээр ирүүлж байгаатай холбоотой. |
| 2 | | 9.21.2. Зорчигч | Холбогдсон дагуул, | Тоо | 2020 | 11 | 2025 | 14 | - | - | Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 20 суурьшилд нийтийн | 100 | ЗТХСайдын 2023 оны 12 дугаар |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна. | хаяа, хот, тосгод | | | | | | | | тээврийн үйлчилгээг 21 чиглэлд хүргэж, өдөр тутам 85 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. | | сарын 05-ны өдрийн Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/306 дугаартай тушаалаар Хот хоорондын нийтийн тээврийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээнд тээвэрлэлтийн чиглэл, зураглалыг тусган, хэрэгжүүлэх ажлыг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-т даалгасан. |
| 3 | | 9.21.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна. | "Агаарын дүүжин замын тээврийн төсөл"-ийн чиглэлийн урт | км | 2020 | 0 | 2025 | 10.1 | - | - | Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Ярмагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км трасст тулгуур багана байрлуулах ажил хийгдэж эхэлсэн.<br>Туул голын ай сав газар байрлалтай 3-9 дүгээр тулгуур баганын нийт 28ш шон суурийн өрөмдлөг, арматурчлал, бетоны ажил хийгдсэн. Дүүжин замын тээврийн төслийн хоёрдугаар шугам буюу Үндэсний соёл амралтын хүрээлэнгээс Үндэсний | 70 | Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Шинэ бүтээн байгуулалт ХК хариуцан ажиллаж байна. |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | цэцэрлэгт хүрээлэн чиглэлийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил эхэлж, дэд бүтэц, суурь судалгааны ажлууд хийгдэж эхэлсэн. | | |
| 4 | 9.22. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоолтой болно. | 9.22.1 Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна. | Байгаль орчинд ээлтэй автобус | Тоо | 2020 | 12 | 2025 | - | 3 тэрбум | 3,008,460,000 | Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, "Юутонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын евро-5 дизель хөдөлгүүртэй, их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багахангай дүүргийн чиглэлд 1, Багануур дүүргийн чиглэлд 2, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлд 7 автобусыг тус тус үйлчилгээнд гаргасан. | 100 | - |
| 5 | | 9.22.2 Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг байгуулсан байна. | Цахилгаан автобус цэнэглэх цэг | Тоо | 2020 | 3 | 2025 | 8 | - | - | 4 байршилд 13 цэнэглэгчээр цахилгаан автобусыг цэнэглэж байна.<br>Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төвд цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах ажлын хүрээнд холбогдох зураг төсөл, төсвийн задаргааг карбон кредит төслийн шугамаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг 2026 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | хамтран ажиллах саналыг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/08/1161 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 7 | | | Шинээр баригдах нийтийн тээврийн зогсоол | Тоо | 2020 | 930 | 2025 | 960 | - | - | Нийслэл Улаанбаатар хотод орон нутгийн хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжаар 2021-2024 онд нийт 144 нийтийн тээврийн зогсоолын байгууламжийг шинээр хийж тохижуулсан дүнтэй байна.Энэ нь шинээр баригдсан зогсоолын тоо нь 2023 оны суурь түвшингөөс 3,8 дахин өссөн үзүүлэлттэй байна. | 100 | - |
| 8 | | 9.22.3 Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулна. | Нийтийн тээврийн үйлчилгээ-ний зогсоолд байршуулах мэдээллийн самбар | Тоо | 2020 | 3 | 2025 | 153 | - | - | Улаанбаатар хотод 1140 дундын, 140 эцсийн зогсоол байна.<br>Нийтийн тээврийн 186 зогсоолд чиглэлийн мэдээллийн самбарт мэдээллийг байршуулсан байна.<br>Жэи Си Деко ХХК 2014-2023 онд нийт 225 автобусны зогсоол байгууламж, нийтийн хэрэгцээнд тохижуулснаас 163 автобусны зогсоолд чиглэлийн мэдээллийн самбар байршсан. 2024 онд нийт 20 зогсоолыг ашиглалтад оруулж мэдээллийн самбарыг байршуулсан бол 2025 оны байдлаар дахин шинэ 3 зогсоолыг шинээр ашиглалтад оруулж шинээр мэдээллийн самбар байрлуулсан байна.<br>Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд орчин | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан нийтийн тээврийн чиглэлийн мэдээллийн зураглалыг боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, Дата дэус ХХК шалгарсан. | | |
| 9 | | | Нийтийн тээврийн үйлчилгээний тохижуулах зогсоол | Тоо | 2020 | 212 | 2025 | 250 | - | - | Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээнд өдөр тутам 1280 зогсоол, эцсийн зогсоолоор ашиглаж байгаа 140 зогсоол байна.<br>Автобусны 1280 зогсоолын 429 зогсоол буюу 33.5 хувь зогсоол нь тохижилттой байна. Хийцлэлийн хувьд авч үзвэл:<br>-Шилэн саравчтай 347 зогсоол<br>-Битүү хийцлэлтэй 61 зогсоол<br>-Дулаан 21 зогсоол байна. Нийт зогсоолын 76.5 хувь нь тохижилтгүй байна.<br>2024 онд Нийслэлийн засаг даргын тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулсан.<br>2025 оны тайлант хугацаанд нийт 3 байршилд шинээр 3 дулаан зогсоолыг байнгын ашиглалтад оруулсан. Суурь түвшний тохижуулах зогсоолын тоотой | 100 | - |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот он | Зорилтот түвшин | Батлагдсан төсөв (сая төгрөг) | Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг) | Хэрэгжилт | Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй бол шалтгаан тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | харьцуулбал тохижилттой зогсоолын тоо 1,2 дахин өссөн үзүүлэлттэй байна. | | |
| 10 | 9.23. Улаанбаатар хотод ачаа тээврийн логистик, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулна. | 9.23.1 Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна. | Зорчигчдын ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал | Тоо | 2020 | 0 | 2025 | 2 | - | - | Улаанбаатар хотын зүүн хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах байршил, техник эдийн засгийн үзүүлэлтийг ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэхээр хүлээгдэж байна.<br>"Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан баруун логистик төв байгуулах зорилт арга хэмжээнд тусгах саналыг 2025 оны 03 дугаар сарын 17-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт /erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын цахим систем/-ээр хүргүүлсэн. | 50 | Улаанбаатар хотын зүүн хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах байршил, техник эдийн засгийн үзүүлэлтийг ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэхээр хүлээгдэж байна. "Улаанбаатар хотын баруун хэсэгт олон улсын ачаа, тээвэр, логистикийн төв байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ төсвийн тодотголоор хасагдсан. |
| Хэрэгжилтийн дундаж хувь:/100*6+70*2+50*1/ | | | | | | | | | | | | 87.7 | |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Ц.ОДМАНДАХ

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ...дугаар сарын....-ны өдрийн .......
дугаар албан бичгийн.... дугаар хавсралт

# "НИЙСЛЭЛ ХОТЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН 2021-2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2025 оны эхний хагас жилийн байдлаар)

2025 оны 06 дугаар сарын 26 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Журам батлах тухай" үндэслэн "Нийслэл хотыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ний хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагаанд тусгагдсан тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2025 оны хагас жилийн байдлаар гарган дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хүрээнд тус газраас 7 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ба хэрэгжилтийн дундаж 88.57 хувь байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 83.2 хувь байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Журам батлах тухай"-ын 6.5.-т заасан үнэлгээний арга зүйгээр Хэрэгжих хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлгээний 1.хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш бол "Үр дүнтэй" үнэлгээтэй байна.

1.2.Бодлогын баримт бичгийн 9.21.3."Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна" гэсэн арга хэмжээ 70 хувийн биелэлттэй буюу хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь үр дүн хүлээгдэж байгаа ба дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

1.Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн газар, шороо, барилга угсралтын ажил Сонгино Хайрхан дүүргээс Хан-Уул дүүрэг Ярмагийн эцсийн зогсоол хүртэлх 4.2 км трасст тулгуур багана байрлуулах ажил хийгдэж эхэлсэн. Туул голын ай сав газар байрлалтай 3-9 дүгээр тулгуур баганын нийт 28ш шон суурийн өрөмдлөг, арматурчлал, бетоны ажил хийгдсэн. Дүүжин замын тээврийн төслийн хоёрдугаар шугам буюу Үндэсний соёл амралтын хүрээлэнгээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэн чиглэлийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил эхэлж, дэд бүтэц, суурь судалгааны ажлууд хийгдэж эхэлсэн. Дүүжин замын тээвэрт Европын Холбооны стандартыг нутагшуулах зорилгоор "Хүн тээвэрлэх зориулалттай дүүжин замын тээврийн байгууламжийн аюулгүй байдлын шаардлага"-тай холбоотой 15 стандартыг СХЗГ-ын Авто тээврийн стандартчиллын техникийн хороогоор батлуулан, MNS бүртгэлд шилжүүлсэн.

2.Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх "Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар" 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг хэлэлцүүлэгт Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагуух Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон.

2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.

Азийн хөгжлийн банк нь "Тусгай замын автобус BRT төсөл"-ийн санхүүжилтийн зээлийн судалгааны ажлын хэсэг байгуулан 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, мэдээ мэдээлэл солилцож санал хүргүүлэн ажилласан.

3.2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарч, төслийн бүтээн байгуулалтын ажлын (EPC) гүйцэтгэгчийг шалгаруулах хоёрдугаар шатны тендерийн баримт бичигт санал, зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, хурлаар тендерийн баримт бичгийг хэлэлцэж холбогдох санал, мэдээллийг өгч ажилласан.

